



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Нийслэлийн Баянгол дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны эргэлтийн
бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,709,000 (нэг сая долоон зуун есөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургуулийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (А.Даваажаргал)-нд зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (А.Даваажаргал), Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль (Д.Нямсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

11505000245

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ны
өдрийн 4/86 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Шилжүүлж өгөх байгууллага | Шилжүүлэн авах байгууллага |
|--|--------------------------|-----------------|------------------------|-------------|------------|-------------|------------------|-----------------------|-------------------|---------------------------|--|
| 1 | Угтвар ширээ /хүрэн бор/ | Төмөр угаалтуур | 2016.04.05 | ш | 1 | 1,259,000 | 1,259,000 | 619,008.53 | 639,991.47 | Баянгол дүүргийн ИТХ | Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль |
| 2 | Савхин модон сандал | Төмөр угаалтуур | 2012.06.21 | ш | 6 | 75,000 | 450,000 | 435,000.00 | 15,000.00 | | |
| Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн | | | | | | | 1,709,000 | 1,054,008.53 | 654,991.47 | | |